БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.24 № 187

танай ____________ -ны № ____________ -т

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА Т.НАЗЫМ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус газрын 2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Created with Scanner Pro

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Created with Scanner Pro

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/07/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Нурлан<br>Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Created with Scanner Pro

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ............ 3
Асуудлыг онцолсон хэсэг ............ **Error! Bookmark not defined.**
Аудитын гол асуудал ............ **Error! Bookmark not defined.**
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ............ 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ............ **Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН ............ 13
4.1 Ерөнхий зүйл ............ 13
4.2 Материаллаг байдал ............ 13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ............ 13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ............ 13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ............ 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............ 14
4.5.1 Завсрын аудитын талаар ............ 14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ............ 14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ............ 14
5.1 Төлбөрийн акт ............ 14
5.2 Албан шаардлага ............ 14
5.3 Зөвлөмж ............ 14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ............ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |



Created with Scanner Pro

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Created with Scanner Pro

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1598500.00** | **5153500.00** |
| 34 | **УРЬДЧИЛГАА** | - | 3500000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 3500000.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,598,500.00 | 1653500.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 1,598,500.00 | 1653500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,598,500.00 | 1653500.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,874,439,579.85** | **1936353883.97** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,874,439,579.85 | 1936353883.97 |
| 392 | **Биет хөрөнгө** | 1846839579.85 | 1908753883.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,831,500,000.00 | 1947110912.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | -61050000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 20,007,604.00 | 32527639.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (9,153,437.19) | -12908037.19 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,488,104.00 | 12488104.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,002,690.96) | -9414733.84 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 27,600,000.00 | 27600000.00 |
| 39301 | Програм хангамж | - | 1200000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 27,600,000.00 | 26400000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,876,038,079.85** | **1941507383.97** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,876,038,079.85** | **1941507383.97** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,876,038,079.85 | 1941507383.97 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 72057976.00 | 72057976.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 72,057,976.00 | 72057976.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 1,801,180,499.85 | 1,866,649,803.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (32,350,326.29) | 1801180499.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,833,530,826.14 | 65469304.12 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,799,604.00 | 2799604.00 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,876,038,079.85** | **1941507383.97** |



Created with Scanner Pro

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,033,473,129.00** | **405,204,325.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **60,912,200.00** | **76,961,400.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 60,912,200.00 | 76,961,400.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 60,912,200.00 | 76,961,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,912,200.00 | 76,961,400.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,972,560,929.00** | **328,242,925.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,831,500,000.00 | 126,180,947.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,807,229.00 | 75,733,478.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 6,231,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,807,229.00 | 69,502,478.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 129,253,700.00 | 126,328,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 129,253,700.00 | 126,328,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **199,942,302.86** | **339,735,020.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **199,942,302.86** | **339,735,020.88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 198,145,025.86 | 289,274,965.88 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 156,393,750.10 | 144,115,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 133,375,858.10 | 111,222,164.00 |
| 210102 | Нэмэгдэл | 20,268,651.00 | 26,862,100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,749,241.00 | 2,880,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 3,150,736.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,433,700.00 | 27,447,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,142,200.00 | 24,356,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,572,900.00 | 772,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,258,300.00 | 618,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 314,600.00 | 154,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,145,700.00 | 1,545,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,143,000.00 | 27,405,540.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,507,700.00 | 11,482,495.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,746,600.00 | 14,154,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,585,700.00 | 1,768,945.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 303,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,806,700.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,806,700.00 | - |



Created with Scanner Pro

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,695,300.00 | 9,847,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,695,300.00 | 9,847,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,683,000.00 | 2,042,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 716,700.00 | 354,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 333,000.00 | 333,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,433,300.00 | 1,155,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,989,575.76 | 78,416,225.88 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,965,422.00 | 11,099,583.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,024,153.76 | 66,216,642.88 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,797,277.00 | 50,460,055.00 |
| **2135** | **Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,797,277.00 | 50,460,055.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,797,277.00 | 50,460,055.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,833,530,826.14** | **65,469,304.12** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,833,530,826.14** | **65,469,304.12** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **201,973,129.00** | **279023378.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **60,912,200.00** | **76961400.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 60,912,200.00 | 76961400.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 60,912,200.00 | 76961400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,912,200.00 | 76961400.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **141,060,929.00** | **202061978.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11807229.00 | 75733478.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,807,229.00 | 75733478.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 129,253,700.00 | 126328500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 129,253,700.00 | 126328500.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **196,067,722.00** | **277073378.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **196,067,722.00** | **277073378.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **194,270,445.00** | **226613323.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 155,585,323.00 | 144115000.00 |



Created with Scanner Pro

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 140,343,523.00 | 114372900.00 |
| 210102 | Нэмэгдэл | 12,532,800.00 | 26862100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,709,000.00 | 2880000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,433,700.00 | 27447700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,142,200.00 | 24356200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,572,900.00 | 772900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,258,300.00 | 618300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 314,600.00 | 154600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,145,700.00 | 1545700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,664,600.00 | 16063945.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,275,700.00 | 7414600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,440,200.00 | 6880400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,645,700.00 | 1768945.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 303,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,806,700.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,806,700.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,695,300.00 | 9847600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,695,300.00 | 9847600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,683,000.00 | 2405600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 716,700.00 | 716700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 200000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 333,000.00 | 333300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,433,300.00 | 1155600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,401,822.00 | 26733478.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,401,822.00 | 25733478.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1000000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,797,277.00** | **50460055.00** |
| **2135** | **Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,797,277.00 | 50460055.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,797,277.00 | 50460055.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,905,407.00** | **1,950,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,905,407.00** | **1950000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,905,407.00** | **1950000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,905,407.00 | 1950000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,905,407.00 | 1950000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(5,905,407.00)** | **-1950000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 0.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**



Created with Scanner Pro

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 72,057,976.00 | 2,799,604.00 | 1,801,180,499.85 | 1,876,038,079.85 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **72,057,976.00** | **2,799,604.00** | **1,801,180,499.85** | 1,876,038,079.85 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **72,057,976.00** | **2,799,604.00** | **1,801,180,499.85** | 1,876,038,079.85 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **72,057,976.00** | **2,799,604.00** | **1,801,180,499.85** | 1,876,038,079.85 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **72,057,976.00** | **2,799,604.00** | **1,801,180,499.85** | 1,876,038,079.85 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 65,469,304.12 | 65,469,304.12 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **72,057,976.00** | **2,799,604.00** | **1,866,649,803.97** | 1,941,507,383.97 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 203289900.00 | 202829845.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 203289900.00 | 202829845.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 203289900.00 | 202829845.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 144115000.00 | 144115000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 114372900.00 | 114372900.00 |
| 210102 | Нэмэгдэл | 26862100.00 | 26862100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2880000.00 | 2880000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27447700.00 | 27447700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24356200.00 | 24356200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 772900.00 | 772900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 618300.00 | 618300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 154600.00 | 154600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1545700.00 | 1545700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16420300.00 | 16063945.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7414600.00 | 7414600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6880400.00 | 6880400.00 |



Created with Scanner Pro

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2125300.00 | 1768945.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9847600.00 | 9847600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9847600.00 | 9847600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4459300.00 | 4355600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 716700.00 | 716700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200000.00 | 200000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 333300.00 | 333300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 70800.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 25000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3113500.00 | 3105600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1000000.00 | 1000000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1000000.00 | 1000000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 203289900.00 | 202829845.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 126328500.00 | 125868445.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 126328500.00 | 125868445.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 76961400.00 | 76961400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 76961400.00 | 76961400.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 12.00 | 12.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7.00 | 7.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **12.0** | **12.0** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 8.00 | 8.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4.00 | 4.00 |

**2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **11,807,229.00** | **25733478.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,807,229.00** | **25733478.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 11,807,229.00 | 25733478.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,807,229.00 | 25733478.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,807,229.00 | 25733478.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 11,807,229.00 | 75733478.00 |



Created with Scanner Pro

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,807,229.00 | 75733478.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,807,229.00 | 75733478.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, түүнд тавих хяналтыг өндөржүүлэх, бүртгэл тооцоог байгууллага бүрээр хөтлөн өмчийн үр ашгийг дээшлүүлэх, худалдан авах ажиллагааны шалгаруулалтыг ил тод, шударга болгож хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй үр дүнтэй ашиглаж, өрсөлдөх тэгш боломж олгох, хариуцлагатай байх нөхцөлийг хангаж ажилладаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Тайлант онд "Төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, мэргэшсэн, мэдлэг чадвар бүхий боловсон хүчнээр эгнээгээ бэхжүүлж, төрийн ёс зүйг чандлан сахиж, нутгийн иргэдийн эрх ашгийг дээдлэн төрийн үйлчилгээг шударга ил тод, шуурхай нээлттэй хүргэж ажиллана" гэсэн зорилтын дор ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Орон нутгийн өмчийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн газар нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Created with Scanner Pro

Орон нутгийн эмчийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Орон нутгийн эмчийн газрын даргын 2019 оны 12 сарын 27-ны өдрийн А/23 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Орон нутгийн эмчийн газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65.4 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилж гарсан зардал | | 3,500.0 | 3,500.0 |
| Бараа материал | 1,598.5 | 1,653.5 | 55.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,874,439.6 | 1,936,353.9 | 61,914.3 |
| **Нийт хөрөнгө** | **1,876,038.1** | **1,941,507.4** | **65,469.3** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,876,038.1 | 1,941,507.4 | 65,469.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,876,038.1** | **1,941,507.4** | **65,469.3** |

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 61.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хандиваар 2.3 сая төгрөгийн, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09-р сарын 05-ны өдрийн 106 тоот хурлын тогтоолоор 115.6 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт, аймгийн Засаг даргын 2021 оны А/157 тоот захирамжаар 8.2 сая төгрөгийг 2020 онд хийгдсэн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, 2.0 сая төгрөг төсвийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 66.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 65.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**



Created with Scanner Pro

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 311.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 311.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 26.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 19.7 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 6.2 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 30.6 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 23.8 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлын 4.6 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 2.1 сая төгрөгөөр бууруулж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 4.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 203.3 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 38.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 203.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 203.3 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 202.8 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаанд 0.4 сая төгрөгийг дутуу зарцуулж, тэр хэмжээгээр орон нутгийн төсөвт төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Төрийн эмчийн эрхийг хэрэгжүүл-70426** | **203,289.9** | **202,829.8** | **460.1** | **99.8%** |
| 1.1 | Үндсэн үйл ажиллагааны зардал-80101 | 203,289.9 | 202,829.8 | 460.1 | 99.8% |
| | **Дүн** | **203,289.9** | **202,829.8** | **460.1** | **99.8%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн эмчийн газар нь 2022 онд 75.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч гүйцэтгэлээр 25.7 сая төгрөг зарцуулж 50.0 сая төгрөгийн төвлөрүүлэн шилжүүлсэн байна.



Created with Scanner Pro

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Орон нутгийн өмчийн газар нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Орон нутгийн өмчийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/19 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Орон нутгийн өмчийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 199.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хангамж бараа материалын зардал 4.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



Created with Scanner Pro

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна. Шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.4.2** Бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3.5 сая төгрөгийн алдаа илэрч залруулав.Санхүүгийн байдлын тайланд вэб сайт хийлгэх зардлыг тайланд хугацааны зардалд оруулсныг урьдчилж гарсан зардлаар залруулав.

*Хууль хяналтын байгууллагад албан шаардлагаар шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн асуудал байхгүй.*

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөгдөөгүй.

**5.3 Зөвлөмж**

Зөвлөмж байхгүй.



Created with Scanner Pro

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 3,5 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлыг бүртгээгүй зөрчил илэрч аудитаар залруулав. | 1 | 3,500.0 | | | | | 1 | 3,500.0 | | | | |
| **Дүн** | **1** | **3,500.0** | | | | | **1** | **3,500.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |



Created with Scanner Pro